



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“ЦАНТ-ОРХОН ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”



Ерөнхий дүгнэлт:

Төлөөлөн удирдах зөвлөл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт сул байгаагаас үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд оршиж буй зөрчил арилаагүй байна.



Сүхбаатар сум 2017 он

Тайланг бэлтгэсэн:
Сэлэнгэ аймаг дах
Төрийн Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх
Аудитор
Б.Эрдэнэзул

2017 оны 09-10 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70363036
дугаарын утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Компанийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

- 1.1. Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
- 1.2. Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу?
- 1.3. Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу?

2. Орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?

- 2.1. Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн, төвлөрүүлж байна уу?
- 2.2 Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?
- 2.3 Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх?

3. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

- 3.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу?
- 3.2 Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу?
- 3.3 Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу?

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТХШС	Төрийн хяналт шалгалтын стандарт
МНААХҮХ	Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААН	Аж ахуйн нэгж
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УЦУОША	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. 1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Цант-Орхон ХХК-ийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

1. Компанийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
2. Орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?
3. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

Аудитад Цант-Орхон ХХК-ийн 2016 оны үндсэн болон санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг хамруулсан болно.

1.3 Аудитын арга зүй

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан Цант-Орхон ХХК-ийн захирал, нягтлан бодогчид, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, компанийн ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хууль, ААНОАТ-ын тухай хууль, НӨАТ-ын тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд болон Сангийн сайдын 2012 оны 77-р тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Б.Эрдэнэзул 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

1.5 Ерөнхий мэдээлэл

Цант орхон ХХК нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 1999 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор үүсэн байгуулагдаж, Мандал сумын

зарим албан газар, аж ахуйн нэгж, хүн амыг цэвэр усаар хангах, аж ахуйн нэгж байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж цэвэрлэх, зөөврийн усан хангамжийн үйлчилгээ, зочид буудал, саун, халууны усаар үйлчлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь захиргаа аж ахуй, нийтлэг үйлчилгээ, ариутгах татуурга гэсэн бүтэцтэй, 48 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Бүлэг 1

Компанийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу.

Цант-Орхон ХХК нь зөвхөн санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж байгаа бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэлэлцүүлээгүй байна.

1.1 Компанийн дүрэм болон улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан зарим үйл ажиллагааг явуулаагүй байна.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 10 сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолын 1-р хавсралтаар “Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Цант-Орхон ХХК-ийн дүрэм”-ийг шинэчлэн баталжээ. Тус дүрэмд үйл ажиллагааны дараах 5 чиглэлийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

1. Мандал сумын албан газар, аж ахуйн нэгж, хүн амыг цэвэр усаар хангах, аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх,
2. Иргэдэд халуун ус, зочид буудал, үсчин, гоо сайхан, дулаан гражаар үйлчилж гадаад дотоод худалдаа эрхэлж, иргэдийн эрэлт хэрэгцээ, зах зээлийн шаардлагад нийцүүлэн ажиллах,
3. Ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, засвар үйлчилгээг график төлөвлөгөөтэй хийн, хэрэглэгчдээс гарсан санал хүсэлтийг цаг тухайд нь барагдуулж ажиллах,
4. Гадаад, дотоод худалдаа эрхэлж, иргэдэд шуурхай чирэгдэлгүй үйлчлэх,
5. Нийт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг хангаж, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж, хамтын гэрээ байгуулан, дүгнэж байх.

Цант-Орхон ХХК нь 1999 онд улсын бүртгэлийн 1314001004 дугаарт бүртгүүлэн, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр усан хангамж ариутгах татуургын, туслах үйл ажиллагааны чиглэлээр иргэдийн үйлчилгээ, халуун ус, үсчин, гутал засвар, ус тээвэрлэж хүргэх үйл ажиллагаа явуулахаар гэрчилгээ авчээ.

Үндсэн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12-р зүйлд заасан 6 төрлийн¹ ажил үйлчилгээ эрхлэхээр 00002 тоот тусгай зөвшөөрлийг Хот, суурины ус хангамж, ариутгах

¹ 12.2.9 бохир ус татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.10 бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.11 ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ; 12.2.12 хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээ; 12.2.13 зөөврийн ус хангамжийн үйлчилгээ; 12.2.14 бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ.

татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс 2012 онд авч, 2015 онд 3 жилийн хугацаатайгаар сунгалт хийлгэсэн байна.

Туслах үйл ажиллагааны чиглэлээс халуун ус, ус тээвэрлэж хүргэх үйлчилгээг эрхэлж байгаа бөгөөд үсчин, гутал засварын үйлчилгээг эрхлээгүй байна. Харин компанийн дүрэмд заасан зочид буудлын үйлчилгээ, гадаад дотоод худалдаа явуулах чиглэл улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдаагүй байна.

Мандал сум дахь ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс болон ариутгах татуургын объектуудад ариун цэвэр хамгаалалтын бүсийн зайг дүрэмд заасны дагуу тогтоогоогүй байна.

Мандал сумын ариутгах татуургын байгууламжаас орон сууцны барилгажилтын хязгаар, олон нийтийн барилгын хэсэг хүртэлх ариун цэвэр хамгаалалтын бүс нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 7 дах заалт², болон Барилга хот байгуулалтын сайдын 2014 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж” дүрмийн 4.20-д зааснаар 200 метрийн зайтай байх ёстой байтал тус сумын ИТХ-ын 2015 оны 90 дүгээр тогтоолоор 60 метр байхаар тогтоосон байна.

Цант-Орхон ХХК нь усан хангамжийн төв гүний худаг, үүнээс зөөвөрлөн иргэдэд ус түгээдэг 5 худагтай бөгөөд эдгээр ус хангамжийн эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоогоогүй байна. Энэ нь Усны тухай хуулийн 22³, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17-р зүйл заалтуудыг⁴ зөрчиж байна.

Аудитын явцад Цант-Орхон ХХК-ийн ус хангамжийн эх үүсвэрийн болон ариутгах татуургын барилга байгууламжуудтай биечлэн танилцахад худгуудад хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, айл өрхүүдийн хашаа ойрхон баригдсэн, хайс хашаа, тэмдэг тэмдэглэгээ хийгдээгүй, төв худгийн харуул хамгаалалт хангалтгүй /камержуулалтгүй, харуул нь эзэнгүй/ зэрэг байдал ажиглагдаж байлаа.

Ус хангамжийн эх үүсвэр гүний худаг. Харуул хамгаалалтгүй, камержуулалтгүй байдал.



² 17.7.Хотын доторх цэвэр усны дамжуулах, түгээх, бохир усны гаргалгааны болон бохир усны цуглуулах, татан зайлуулах шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байна.

³ 22.1.Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно.

⁴ 17.4.1.хот, суурины төвлөрсөн бүс ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд;



3-р худагт айл өрхийн хашаа тулж баригдсан байдал.

1.2 Цант-Орхон ХХК нь үйл ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж, хэлэлцүүлээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;” эрхтэй гэж заажээ.

Сэлэнгэ аймгийн ИТХ-аас 2015 онд орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны тухай хэлэлцэн ТУЗ, гүйцэтгэх захирал нарт үйл ажиллагааны менежментээ сайжруулан зардлаа хэмнэж, өр авлагаа бууруулах талаар идэвхи санаачлагатай ажиллах, иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанар хүртээмжийг дээшлүүлэн, хэрэглэгчийн тоог өсгөх замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх, цэвэр усны шугамд холбогдсон айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад усны тоолуур суурилуулж, бодит хэрэглээг тооцох, усны алдагдлыг бууруулах зэрэг үүрэг даалгавруудыг өгч байсан бөгөөд 2016 онд Цант-Орхон ХХК-ийн үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг хэлэлцээгүй байна.

Цант-Орхон ХХК-ийн ТУЗ-ийг аймгийн ИТХ-ын 2010 оны 49, 2017 оны 10 дугаар тогтоолоор тус тус өөрчлөн байгуулсан бөгөөд дарга, 4 гишүүнтэйгээр баталжээ.

ТУЗ-ийн хурлыг Компанийн дүрэмд⁵ жилд 2-оос доошгүй, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 130 дугаар тогтоолоор баталсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д⁶ улирал бүр хуралдуулна гэжээ. Гэвч жилд нэг удаа хуралдаж ирсэн бөгөөд 2016 оны хуралдаанаар 2015 оны үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх, үйлдвэрлэлийн төлөвлөгөө батлах, гүйцэтгэх захиралд урамшуулал олгох, кафе ажиллуулах, удирдах зөвлөлийн төсөв батлах зэрэг асуудлыг хэлэлцэж 5 тогтоол гаргасан байна.

⁵ Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Цант-Орхон ХХК-ийн дүрэмийн 6.1.5 “Удирдах зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй хийнэ.”

⁶ Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах нийтлэг журмын 2.2 ТУЗ-ийн ээлжит хурлыг улирал бүр хуралдуулна. ...

Үйл ажиллагааны дүрмийн 6.1.2, 6.1.3-т заасан санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэж, төсөв баталж байгаа ч дараах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаагүй, гүйцэтгэлийг хэрхэн үнэлсэн нь тодорхойгүй, цаашид авах арга хэмжээг тодорхойлоогүй,
- ТУЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, хийсэн ажлын тайлан гаргаагүй, хурлын протокол хөтлөөгүй.
- ТУЗ-ийн ажиллах журмыг батлаагүй, жилд нэг удаа хуралдсан ч ажлын гүйцэтгэлийг үндэслэн цалин олгоогүй байна.

Тус компанийн захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль⁷ болон компанийн дүрэмд⁸ заасны дагуу аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө батлуулаагүй тул жилийн ажлын төлөвлөгөө батлан, мөрдөж иржээ.

Цант-Орхон ХХК нь 2016 онд нийт 114 ажил хийхээр төлөвлөснөөс 74 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 5 ажлыг дутуу, 36 ажлыг огт хийгээгүй бөгөөд нийт төлөвлөсөн ажлын хэрэгжилт 70 орчим хувьтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хийх ажлын тоо	Үүнээс	
			Дутуу хэрэгжсэн	Огт хэрэгжээгүй
1	Дотоод ажил	16		2
2	Нийгмийн чиглэл	10		2
3	Ус хангамж	8		1
4	Ариутгах татуурга	24		7
5	Засвар өргөтгөл шинэчлэл	17		6
6	Зочид буудал	10		9
7	Халуун ус	7		2
8	Цахилгаан	14		7
9	Авто граж	8	5	
Нийт дүн		114	5	36

Цаашид үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, жилийн төлөвлөгөө зэргийг улс, орон нутгийн бодлого, чиглэлтэй уялдуулан боловсруулж, ТУЗ, аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжүүлж, гүйцэтгэлийг үнэлүүлж байх шаардлагатай байна.

1.3 Дотоод хяналт, шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгахаар төлөвлөн ажиллаж байна.

Аудитад хамрагдсан хугацаанд үндсэн үйл ажиллагаатай холбоотой 5, Татварын тухай хуулийн хэрэгжилттэй 1 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна.

Аймгийн МХГ болон УЦУОША-аас жилд 1-2 удаа ундны усны болон бохир усны чанар нь эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхэд шинжилгээ хийж хянадаг ба бактерлогийн шинжилгээг МХГ-аар, химийн шинжилгээг Ус цаг уур, орчны шинжилгээний албаар тус тус хөндлөнгийн хяналт хийлгэдэг байна.

⁷ 19.1 1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна..., 78-р зүйл Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын бүрэн эрх 78.2.2 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;

⁸ 7.1 Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

УЦУОША-аас бохир усны шинжилгээг авдаг ч 2016 онд тус компани нь ариутгах татуургын барилга байгууламжид их засвар хийсэнтэй холбоотойгоор уг шинжилгээ хийгдээгүй байна. 2017 оны 6 дугаар сард авсан шинжилгээгээр умбуур бодис байх ёстой хэмжээнээс 4.4 дахин их, бусад 10 үзүүлэлт хэвийн, нийт цэвэршилт 93.4 хувьтай гарсан байна.

Бусад байгууллагаас үндсэн ажиллагаатай холбогдолтой 5 удаагийн хяналт шалгалт хийгдэж, 23 зөрчлийг арилгах албан шаардлага өгөгдсөнөөс 16 зөвлөмж хэрэгжиж, 1 нь хэрэгжээгүй, 6 нь хэрэгжих шатандаа явж байна. Тодруулбал:

- Аймгийн МХГ-аас 2016 оны 9-р сард төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, нийт 9 төрлийн зөрчлийг арилгуулахаар 8-03-011/2 дугаар бүхий албан шаардлага өгсөнөөс ундны усны түгээх байруудын өнгө үзэмжийг сайжруулан хамгаалалтын хашаа хайс барих, орчин тойрныг зүлэгжүүлэн тохижуулах гэсэн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Харин дараах зөрчлийг арилгахаар баримт материалыг судлан цуглуулах, 2017, 2018 онд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөн, тодорхой арга хэмжээ авч байна.

- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй,
- Лагийн ариутгал халдваргүйтэл хийгдээгүй,
- Яндан тус бүрт тортог баригч малгай, шүүлтүүр хийгээгүй,
- Түүхий нүүрсний хэрэглээг багасгах,
- Ундны ус зөөх машиныг зориулалтын болгох, шаардлага хангахгүй болсон ус нөөцлөх савнуудыг солих,
- Лабораторын итгэмжлэлийн талаар судалгаа, бэлтгэл ажлыг хийж итгэмжлэлд хамрагдах.

Мөн МХГ-аас 2016 оны 6-р сард ундны усны эх үүсвэрийн гүний худаг, усан сангууд, цэвэрлэх байгууламжийн бохир ус, шүүх талбай орчмын хөрснөөс дээж авч нян судлалын болон химийн шинжилгээнд хамруулахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Гүний худаг, 4-р усан сангийн усанд нянгийн тоо зөвшөөрөгдөх хэмжээнээс их,
- Бүх объектод гэдэсний бүлгийн бактери илэрсэн,
- Цэвэрлэх байгууламжийн орох, гарах хэсэгт гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бактери илэрсэн байна.

Үүний дагуу Цант-Орхон ХХК-ийн лабораториас угаалга ариутгал хийж, актаар баталгаажуулсан байна.

Харин аймгийн Татварын хэлтсээс Цант-Орхон ХХК-ийн 2012-2015 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийжээ. Хяналт, шалгалтаар татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөөгүй болон бусад орлогод татвар ногдуулаагүй байсан зэрэг 25,935.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2,090.8 мянган төгрөгийг нөхөн төлөх төлбөрийн акт тогтоосныг барагдуулан ажилласан байна.

Санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд бусад байгууллагаас ямар нэгэн дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Цант-Орхон ХХК нь өөрийн лабораторид усны сорьц шинжилгээ хийж байгаа ч Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт MNS0900:2005 стандартын дагуу магадлан итгэмжлэгдээгүй байна.

Тус компанийн лаборатори нь 2016 онд төв болон зөөврийн 6 усан сангаас /ус хангамжийн эх үүсвэр төв гүний худаг, зөөврийн 5 худаг/ сар бүр химийн болон бактерлогийн 19 үзүүлэлтээр, бохир ус ариутгах татуурга цэвэрлэх байгууламжийн орж гарч буй бохир усанд 3 цэгээс 18 үзүүлэлтээр дээж, шинжилгээ хийжээ.

Гэвч шинжилгээний үр дүнг үнэлсэн, зөрчилтэй гарсан усан сангуудад ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаарх тайлан, мэдээ гаргаагүй, шинжилгээний мөрөөр арга хэмжээ аваагүй байна.

Бүлэг 2

Орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу.

Цант-Орхон ХХК нь санхүүгийн үр ашгийн төлөвлөгөөг бодитой төлөвлөж батлуулаагүй, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Оршил

Цант-Орхон ХХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 02/16 дугаар тогтоолоор 2016 оны үр ашгийн төлөвлөгөөг баталсан бөгөөд 651,542.0 мянган төгрөгийн орлого олж, 648,608.4 мянган төгрөгийн зарлага гарган, 2,640.2 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан ч орлого 7.5 хувиар давж, зарлага 4.9 хувиар хэтэрч, 17,734.5 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Мөн төлөвлөгөөнд 15,000.0 мянган төгрөгийн авлага, 7,000.0 мянган төгрөгийн өглөгтэй байхаар баталсан ч авлагыг 33,008.8 мянган төгрөгөөр, өглөгийг 3,995.5 мянган төгрөгөөр илүү үүсгэсэн байна.

2.1 Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 7.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Үйл ажиллагааны орлого 48,715.7 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар давсныг чиглэлээр нь авч үзэхэд түрээсийн орлого 8.7 хувиар, төвлөрсөн шугамаар бохир ус татан зайлуулах үйлчилгээний орлого 16.2 хувиар давж, бусад орлого 3.9-29.0 хувиар тасарсан байна. /Хүснэгт 3-т харуулав /.

Борлуулалтын орлогын 70 орчим хувийг бүрдүүлдэг Спирт бал бурам ХХК-ийн сул зогсолт төлөвлөснөөс бага хугацаатай байснаас шалтгаалан төвлөрсөн шугамаар бохир ус татан зайлуулах үйлчилгээний орлого 73,390.2 мянган төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Мөн хүүгийн болон бусад орлогыг санхүүгийн төлөвлөгөөнд тооцож тусгаагүйгээс 16,556.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн нь орлого давсан үзүүлэлтэд нөлөөлсөн байна.

Харин үйлчилгээний чанар байдал, үйлчлүүлэгчдэд ээлтэй, тав тухтай орчныг бүрдүүлэх, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх зэргээр бусад орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

2.2 Цант-Орхон ХХК нь давсан орлогыг зөвшөөрөлгүй зарцуулснаар батлагдсан төсвийг 4.9 хувиар хэтрүүлсэн байна.

2016 онд нийт 648,608.4 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн ч 680,098.4 мянган төгрөгийн зардал гаргаж батлагдсан зардлын төлөвлөгөөг 29,445.0 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар хэтрүүлжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.

мян.төгрөгөөр

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны		(хэмнэлт) хэтрэлт	Хувиар
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Орлого ДҮН	651,542.0	700,257.7	48,715.7	107.5
1	Төвлөрсөн шугамаар бохир ус татан зайлуулах	454,353.5	527,743.7	73,390.2	116.2
2	Автомашинаар бохир ус татан зайлуулах	101,400.5	72,352.5	(29,048.0)	71.4
3	Цэвэр ус түгээсний орлого	7,128.0	6,559.8	(568.2)	92.0
4	Халуун усны үйлчилгээний орлого	56,300.0	45,473.0	(10,827.0)	80.8
5	Зочид буудлын үйлчилгээний орлого	26,600.0	25,564.5	(1,035.5)	96.1
6	Биллъяардын үйлчилгээний орлого	1,080.0	920.0	(160.0)	85.2
7	Түрээсийн орлого	4,680.0	5,087.6	407.6	108.7
8	Бусад орлого		16,556.6	16,556.6	
2	Зарлага ДҮН	648,608.4	680,098.4	29,445.0	104.9
1	Цалин	284,804.9	280,629.3	(4,175.6)	98.5
2	НД-ийн болон ЭМД-ийн зардал	31,328.5	30,869.2	(459.3)	98.5
3	Цахилгаан эрчим хүчний зардал	37,937.2	43,721.1	5,783.9	115.2
4	Шатахуун тослох материалын зардал	33,636.4	31,422.7	(2,213.7)	93.4
5	Нүүрс, түлшний зардал	39,065.0	46,913.5	7,848.5	120.1
6	Холбооны зардал	2,992.7	3,214.4	221.7	107.4
7	ХАА, эрүүл ахуйн зардал	4,804.0	4,860.9	56.9	101.2
8	Томилолтын зардал	2,500.0	2,826.4	326.4	113.1
9	Сургалтын зардал	5,000.0	2,360.0	(2,640.0)	47.2
10	Тэтгэмж, шагнал, урамшуулал, тусламж,	5,000.0	5,490.0	490.0	109.8
11	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	90,000.0	90,569.4	569.4	100.6
12	Материалын зардал	50,000.0	54,908.9	4,908.9	109.8
13	Үйл ажиллагааны бус зардал	10,000.0	10,063.7	63.7	100.6
14	Татвар төлбөр хураамж	11,661.9	15,069.5	3,407.6	129.2
15	Тоног төхөөрөмжийн шинэчлэлт, их засварын зардал	33,500.0	50,599.8	17,099.8	151.0
16	Удирдах зөвлөлийн зардал	6,377.8	4,534.6	(1,843.2)	71.1
17	Хандив тусламжийн зардал		2,045.0	2,045.0	
3	Үйл ажиллагааны ашиг (1-2)	2,933.6	20,159.3	19,270.7	687.2
4	Орлогын татвар (3*10%)	293.4	2,424.9	2,131.5	826.5
5	Цэвэр ашиг - алдагдал (3-4-5)	2,640.2	17,734.4	17,139.2	671.7

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэл, шатахуун тослох материал, сургалт, удирдах зөвлөлийн зэрэг 5 төрлийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд 1.5-52.8 хувиар хэмнэж, төлөвлөөгүй хандив тусламжийн зардалд 2,045.0 мянган төгрөгийг зарцуулж, бусад 11 төрлийн зардлыг 0.6-29.2 хувиар хэтрүүлсэн байна.

Энэ нь санхүүгийн төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, батлагдсан төсвийг мөрдөж ажиллаагүйг харуулж байна.

Зардал хэтрүүлсэн шалтгааныг судлахад 4 төрлийн 15,298.9 мянган төгрөгийн зардлыг бодитой төлөвлөөгүйгээс, 6 төрлийн 10,725.8 мянган төгрөгийн зардлыг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулснаас шалтгаалсан бол 2 төрлийн 16,797.1 мянган төгрөгийн зардал зайлшгүй нөхцөл байдлын улмаас хэтэрсэн байна.

Тодруулбал:

Зардлыг бодитой төлөвлөөгүйгээс төсөв хэтрүүлсэн:

- Нийт төлбөр хураамжийн зардлыг 3,407.6 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн бөгөөд үүнээс тээврийн хэрэгслийн, бууны, усны татварууд, тээврийн хэрэгслийн даатгал, үзлэгийн хураамж, аудитын, зохицуулах үйлчилгээний хөлс, бусад төлбөр хураамжийг 51.6-1,650.0 мянган төгрөгөөр,
- Тоног төхөөрөмж шинэчлэлт, их засварын зардлыг үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан батлуулаагүйгээс 10,995.5 мянган төгрөгөөр,
- Бараа материалын татан авалттай холбоотой албан томилолтын зардлыг тооцоолоогүйгээс 326.4 мянган төгрөгөөр,
- Шинээр авах үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоолоогүйгээс 569.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Арвилан хэмнэлтгүй, дотоод хяналтгүй зарцуулснаас батлагдсан төсвийг хэтрүүлсэн бөгөөд хэмнэж болох байсан зардал:

- Үртэсний олдоц муудаж нүүрсний худалдан авалт нэмэгдсэнээр халаалтын зардал 7,848.5 мянган төгрөгөөр хэтэрсэн гэж байгаа ч үйл ажиллагаандаа ашиглаж байгаа халаалтын зуухнуудын хүчин чадал, норм нормативыг тогтоон, анхан шатан дахь зарцуулалтад тавих хяналтыг сайжруулснаар уг зардлыг хэмнэх боломжтой байна.

Тус компани нь тайлант онд 46,913.5 мянган төгрөгийн түлээ, нүүрс хэрэглэсэн бөгөөд халаалтын зуухны хүчин чадал, норм нормативыг тогтоогоогүй, гаргаж буй дулаанд хэмжилт хийдэггүй, нүүрс, үртсийг бөөн дүнгээр шаардахаар зарлагдаж байгаа нь халаалтын зардал, материалын үлдэгдэл бодитой илэрхийлэгдэхгүй байх, өмч хөрөнгийг ашиглан шамшигдуулах эрсдлийг дагуулж байна.

- Холбоо, эрүүл ахуй, үйл ажиллагааны, бусад зэрэг 3 төрлийн 342.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэх боломжтой байна.
- Тэтгэмж, шагнал, урамшууллын зардал 490.0 мянган төгрөгөөр хэтэрсэн бөгөөд энэ нь бүсийн тэмцээнд амжилттай оролцсон гэсэн шалтгаанаар захирал өөртөө 300.0 мянган төгрөгийн, бусад ажилтнуудад 750.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосонтой холбоотой байна.
- Тайлант хугацаанд нийт 13 иргэн, аж ахуйн нэгжид 2,045.0 мянган төгрөгийн хандив өгч зориулалт бус зардал гаргасан байна.

Урьдчилан тооцоолох боломжгүй, зайлшгүй нөхцөл байдлын улмаас үүссэн зардал:

- Цахилгаан эрчим хүчний зардал нь трансформатор эвдэрсэн тул шинэчлэл хийсэнтэй холбоотойгоор 15.2 хувиар буюу 5,783.9 мянган төгрөгөөр хэтэрсэн,
- МХГ-аас аэротенкийн байгууламжийг засварлах албан шаардлага өгсний дагуу 11,013.2 мянган төгрөгийн төлөвлөөгүй засварын ажил хийгдсэн.

Аудитаар, хөрөнгийн зарцуулалт болон дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах 9 төрлийн 189,832.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. ТУЗ-ийн 2016 оны 02/16 дугаар тогтоолоор баталсан үр дүнгийн төлөвлөгөөнд шагналт цалингийн хувийг 1-6 сард 20 хувиар, 7-12 сард 25 хувиар олгохоор баталсан ч гүйцэтгэх захирлын 2016 оны Б/17 дугаар тушаалаар 30 хүртэл хувиар, Б/58 дугаар тушаалаар 40 хүртэл хувиар олгохоор өөрчилсөн байна. 2016 онд 3-р сараас эхлэн 30 хүртэл хувиар бодож олгосон бөгөөд тайлант хугацаанд дунджаар 7,367.8 мянган төгрөгийн шагналт цалинг ТУЗ-ийн шийдвэргүйгээр бодож олгосон байна.

2. Шатахуун, тослох материалын хөдөлгөөний бүртгэлийг бодитой хөтлөхгүй байгаагаас жолооч нарын нэр дээр үлдэгдэлтэй байгаа 96.2 литр буюу 156.0 мянган төгрөгийн шатахууныг зардлаар бүртгэсэн байна.
3. Компанийн гүйцэтгэх захирал тайлант онд 7 удаагийн 5,247.0 мянган төгрөгийн дараа тайлангийн тооцоо үүсгэн, худалдан авалтыг бэлэн мөнгөөр гүйцэтгэсэн байна.
4. Тайлант хугацаанд зориулалт нь тодорхойгүй, хүмүүс хооллосон болон архи, дарс худалдан авсан 11 удаагийн 1,072.9 мянган төгрөгийн зардалд хөрөнгө зарцуулах захирлын тушаал гаргаагүй, төсөв хийж батлуулаагүй байна.
5. ТУЗ-ийн шийдвэрээр 2015 оны үйл ажиллагааны үр дүнгийн цэвэр ашгийн 20 хувиар буюу 9,592.7 мянган төгрөгийн урамшууллыг олгохдоо 2,014.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож аваагүй байна.
6. Компанийн гүйцэтгэх захиралд ТУЗ-ийн болон аймгийн Засаг даргын шийдвэргүйгээр 13-р сарын цалинг 98.6 хувиар тооцож 737.4 мянган төгрөгийг бодож олгосон байна.
7. Харилцахын ажил гүйлгээнд харилцагч байгууллагуудын нэхэмжлэх, данс өөрчлөн шилжүүлэх албан хүсэлт зэрэг баримтыг хавсаргаагүй байгаа нь тухайн ажил гүйлгээг үнэн зөв хийгдсэн эсэхийг нотолж чадахгүй байна. Тайлант онд томоохон хэмжээний 9 удаагийн 16,050.0 мянган төгрөгийн худалдан авалтыг нийлүүлэгч компанийн зарлагын баримтыг үндэслэн хөрөнгө, материалын дансанд бүртгэсэн ч харилцахын гүйлгээг хувь хүний харилцах дансруу ямар ч нэхэмжлэл, албан хүсэлтгүйгээр шилжүүлсэн байна.
8. Бараа материалыг даргын зөвшөөрөлгүйгээр, хүлээн авсан хүний гарын үсэггүйгээр болон бөөн дүнгээр зарлагдаж байна. Тус компанийн 3-р улирлын бараа материалын тайланг түүвэрт хамруулан, анхан шатны баримт материалыг тулгаж үзэхэд дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:
 - нийт орлого 45,212.7 мянган төгрөгийн 6.2 хувь буюу 2,841.0 мянган төгрөгийн нийлүүлэгч байгууллагын зарлагын баримт хүлээлгэн өгсөн, хүлээн авсан, шалгасан нягтлан бодогчийн гарын үсэггүй,
 - нийт бараа материалын зарлага 36,863.8 мянган төгрөгийн 52.0 хувь буюу 19,158.6 мянган төгрөгийн шаардах, талон хүссэн өргөдөлд даргын гарын үсэггүй, ихэнх нь хүлээн авсан ажилтны гарын үсэггүй байна.
9. Нийт мөнгөн орлогын гүйлгээний 35.3 хувийг буюу 268,181.9 мянган төгрөгийг бэлэн авч зарцуулсан ч кассын тайланд бэлэн мөнгөөр тооцоо хийснийг нотлох орлогын ордер, шилжүүлгийн баримт байхгүй, бэлэн мөнгөний хүсэлт, зарлагын баримтад дарга, нягтлан бодогч, хүлээн авагчийн гарын үсэг, тэмдэг дутуу байхад ажил гүйлгээ хийсэн зэрэг алдаа нийтлэг оршиж байлаа. Тухайлбал:
 - Захирал, нягтлан бодогч, бэлэн мөнгө хүлээн авагчийн гарын үсэггүй 74,756.7 мянган төгрөгийн,
 - Кассын тайланд аж ахуйн нэгж, байгууллагуудын төлбөрийг бэлнээр болон шилжүүлгээр хийснийг нотлох баримтгүйгээр 60,430.4 мянган төгрөгийн /500.0 мянган төгрөгөөс дээш/ ажил гүйлгээг тус тус хийж, бүртгэлд тусгасан байна.

Байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд Ординат ХХК-ийн “Виница” програмыг ашиглож байгаа ч зөвхөн мөнгөн хөрөнгө, бараа материалын хөдөлгөөнийг бүрэн хөтөлж бусад бүртгэлийг гараар хөтөлж, санхүүгийн тайланг гараар гаргаж байна. Тухайлбал:

- Бохир усны борлуулалтын орлогын бүртгэлийг санхүүгийн програмд холбоогүй бөгөөд хариуцсан байцаагч нартай тооцоо хийсний дагуу бөөн дүнгээр орлого хүлээн зөвшөөрч бүртгэдэг,
- Өглөг, авлагын журналыг бүрэн хөтлөөгүйгээс програмд харилцагчдын үлдэгдэл бодитой илэрхийлэгдээгүй,

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн журналыг хөтлөөгүй зэргээс шалтгаалан санхүүгийн тайланг програмаар гаргаагүй байна.

Цаашид санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, бүртгэлийг санхүүгийн программаар иж бүрэн хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж байх шаардлагатай байна.

2.3 Тус компани нь ашигтай ажиллаж, авлага, өглөгийг тухай бүр шийдвэрлүүлж хэвшсэн байна.

Цант-Орхон ХХК-ийн сүүлийн 5 жилийн ашиг, алдагдлыг харахад 2012 онд 11,464.8 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бөгөөд 2013 оноос эхлэн 11,745.6-47,963.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3.

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Ашиг, (алдагдал) /мян.төг/	-11,464.8	11,745.6	30,132.2	47,963.4	17,734.4

Цант-Орхон ХХК нь 2016 онд нийт 48,008.8 мянган төгрөгийн авлага, 10,995.5 мянган төгрөгийн татварын өглөгтэй тайлагнагдсан байна.

Авлагын талаар

Авлагыг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд 37.6 хувиар буюу 28,983.0 мянган төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь байгууллагаас болон ажилчдаас авах авлага буурсантай холбоотой байна.

Авлагыг бүтцээр нь авч үзэхэд нийт авлагын 88.7 хувийг борлуулалтын, 6.5 хувийг хүмүүсээс авах, 4.8 хувийг ажилчдаас авах авлага тус тус эзэлж байна. Үүнээс Спирт бал бурам ХХК-иас авах 20,534.0 мянган төгрөгийн борлуулалтын авлага нь нийт авлагын 42.8 хувийг эзэлж байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4.

мян.төг

д/д	Авлагын дансны төрөл	Өмнөх он	Тайлант он	Нийт авлагад эзлэх %
1	Байгууллагаас авах авлага	55,885.2	28,697.7	59.8
2	Айл өрхөөс авах авлага	13,476.5	13,861.0	28.9
3	Ажилчдаас авах авлага	4,480.0	2,300.0	4.8
4	Хувь хүмүүсээс авах авлага	3,150.0	3,150.0	6.5
Нийт авлагын дүн		76,991.7	48,008.7	100

2016 оны жилийн эцсийн авлагыг насжилтаар нь авч үзэхэд 8.3 хувь нь хугацаандаа төлөгдөөгүй авлага байна.

Хүснэгт 5.

Авлага үүссэн он	Авлагын дүн /мян.төг/	Нийт дүнд эзлэх хувь
2016	44,013.9	91.7
2015	844.8	1.8
2014	150.0	0.3

2013	3,000.0	6.2
Нийт дүн	48,008.7	100.0

Үүнээс 2013, 2014 онд Дорж, Мэдсайхан гэх 2 хувь хүнтэй холбоотой үүссэн 3,150.0 мянган төгрөгийн авлагыг өнөөг хүртэл барагдуулаагүй, барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахдаа харилцагч 14 байгууллагатай үүссэн 3,848.9 мянган төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, бусад харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг⁹ зөрчиж байна.

Тус компани нь хугацаа хэтэрсэн авлагыг тухай бүр шүүхэд өгч шийдвэрлүүлж байснаар насжилт ихтэй авлага үүсгээгүй байна. Тухайлбал 2016 онд 49.9-197.0 мянган төгрөгийн тооцоо үүссэн 44 айл өрхийг шүүхэд өгч, шийдвэрлүүлсэн байна.

Богино хугацаат өр төлбөрийн талаар

Тус компани нь татварын 10,995.5 мянган төгрөгийн өглөгтэй бөгөөд бусад харилцагчидтай тооцоо үүсгээгүй байна.

Цаашид санхүүгийн тайланг гаргахдаа үүссэн авлага, өглөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх шаардлагатай байна.

Бүлэг 3

Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу.

Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөөгүй байна.

3.1 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Цант-Орхон ХХК нь ТБОНӨХБАҮХА тухай хууль, Засгийн газрын 68-р тогтоолоор баталсан босго үнээс давсан 2 төрлийн нийт 77,110.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад холбогдох хууль, дүрмийг мөрдөөгүй байна.

Хүснэгт 6.

Мян.төг

д/д	Барааны нэр	Зардлын дүн /жилээр/	Нийлүүлэгч байгууллагууд
1	Нүүрс	42,500.0	300,0 мянган төгрөгийн 1 удаагийн худалдан авалтыг Тээвэрчин ХХК-иас бусдыг Сэлэнгэ тэнгэр хараа ХХК-иас авсан.
2	Шатахуун	33,610.0	НИК, Магнай трейд шатахуун түгээх газар
	Нийт дүн	76,110.0	

Тус компани нь томоохон хэмжээний тоног төхөөрөмж, бараа материалыг худалдан авахдаа холбогдох инженер, техникийн ажилтнуудаас хүчин чадал, үзүүлэлтийн талаар захиалга авдаггүй, бэлтгэн нийлүүлсэн тоног төхөөрөмж, материалын чанар байдлыг шалгаж хүлээн авсан акт үйлддэггүй, өөрөөр хэлбэл хөрөнгийн худалдан авалтад дотоод хяналт хангалтгүй байгаа нь ажиглагдлаа.

⁹19.1.4. эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах;

Тухайлбал, тайлант онд 16 төрлийн 53,120.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авсан ч захиалгын хуудасгүй, хүлээж авсан акт үйлдээгүй байна.

Цаашид орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, тоног төхөөрөмж, бараа материалын захиалгыг холбогдох инженер, техникийн ажилтнуудаас авч, нийлүүлсэн барааг комисс хүлээн авч акт үйлдэж байх шаардлагатай байна.

3.2 Үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэргүйгээр акталж ирснийг өмнөх аудитаар зөвлөмж өгч зогсоосон байна.

Цант-Орхон ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн ИТХ-ын 2013 оны 104 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын дагуу үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг олж авах, шилжүүлэх, устгах, данснаас хасах ёстой.

Гэвч 2016 онд аймгийн ИТХ-аас зөвшөөрөл авалгүйгээр байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 9 нэр төрлийн 4,550.8 мянган төгрөгийн компьютер техник, тавилга эд хогшлыг акталж, устгасан байна. Уг зөрчлийг арилгуулахаар санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгснийг компанийн удирдлагын зүгээс хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.3 Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна.

Жилийн эцсийн эд хөрөнгийн үлдэгдлийг компанийн гүйцэтгэх захирлын 2016 оны А/09 тоот тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2016 оны 12 дугаар сарын 19-өөс 23-ны өдрийн хооронд тоолж баталгаажуулсан байна.

Тооллогоор газраас бусад 3,756,191.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 51,674.5 мянган төгрөгийн бараа материал тоологдсон байна. Үүнээс 3,294,619.2 мянган төгрөгийн барилга байгууламж, 207,563.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 189,272.5 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 56,122.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 8,613.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийн үлдэгдэл тоологдсон байна.

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Цант-Орхон ХХК нь зөвхөн санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж байгаа бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэлэлцүүлээгүй байна.
2. Мандал сум дахь ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс болон ариутгах татуургын объектуудад ариун цэвэр хамгаалалтын бүсийн зайг дүрэмд заасны дагуу тогтоогоогүй байна.
3. ТУЗ нь дүрэмд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
4. Цант-Орхон ХХК нь өөрийн лабораторид усны сорьц шинжилгээ хийж байгаа ч Ундны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт MNS0900:2005 стандартын дагуу магадлан итгэмжлэгдээгүй, шаардлагатай тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан зарим үзүүлэлтийг шинжлэн хянаж чадахгүй байна.

5. Цант-Орхон ХХК нь санхүүгийн үр ашгийн төлөвлөгөөг бодитой төлөвлөж батлуулаагүй, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.
6. Санхүүгийн програмыг иж бүрэн ашиглахгүй байна.
7. Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байна.
8. Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөхгүй байна.

Илэрсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнд нийт **352,644.6** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч **134,097.5 мянган** төгрөгийн зөрчилд албан шаардлага, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой **218,547.1 мянган** төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

Албан шаардлага:

- 1 ТУЗ-өөр баталсан үр ашгийн төлөвлөгөөг 29,445.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан,
- 2 Компанийн захиралд ТУЗ-ийн болон аймгийн Засаг даргын шийдвэргүйгээр 300.0 мянган төгрөгийн шагнал, 737.4 мянган төгрөгийн 13 дахь сарын цалин бодож олгосон,
- 3 Гүйцэтгэх захирлын урамшууллаас 2,014.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцоогүй,
- 4 ТУЗ-ийн шийдвэргүйгээр шагналт цалингийн хувийг нэмж 7,367.8 мянган төгрөгийг зарцуулсан,
- 5 Харилцахаас нэхэмжлэл, дагалдах баримтгүйгээр 16,050.0 мянган төгрөгийн гүйлгээг хувь хүний дансруу шилжүүлсэн,
- 6 Гүйцэтгэх захирлын баталсан тушаал, төсөвгүйгээр 1,072.9 мянган төгрөгийн зардлыг үр ашиггүй зарцуулсан,
- 7 77,110.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөөгүй байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Цант-Орхон ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Стратеги төлөвлөгөө болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, мөрдүүлэх, жил бүр гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж байх.
2. ТУЗ-ийн үйл ажиллагааг үр нөлөөтэй, үр ашигтай болгох, ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үндэслэн цалин хөлс авдаг нөхцлийг судалж нэвтрүүлэх.
3. Цант-Орхон ХХК-ийн дүрэм болон аймгийн ИТХ-ын 2013 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан журмыг мөрдөж ажиллах.

Цант-Орхон ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бат-Эрдэнэд:

1. Компанийн стратеги төлөвлөгөө болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан, мөрдөж ажиллах.
2. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дагуу хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоогүй ус хангамжийн эх үүсвэрүүдэд бүс тогтоолгох саналыг сумын ИТХ-аар батлуулах.
3. Эдийн засгийн үр ашгийн тооцоог бодитой тооцоолсны үндсэн дээр санхүүгийн төлөвлөгөөг батлуулах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж байх.
4. Зуухны норм нормативыг тогтоож, түлээ, нүүрсний зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулж, бүртгэлийг бодитой хөтлөх.
5. Төсвийн тухай хуулийг мөрдөж иргэн, аж ахуйн нэгжид хандив өгөх асуудлыг зогсоох.
6. Гүйцэтгэх захирал нь нярвын үүргийг гүйцэтгэж дараа тайлангаар худалдан авалт хийхгүй байх.
7. Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтын үүргээ хэрэгжүүлж, бэлэн мөнгөний болон бараа материалын зарцуулалтад анхан шатны баримт материалыг үндэслэн гүйлгээ хийх зөвшөөрлийг өгч байх.
8. 2013 оноос үүссэн 3,150.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах.
9. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж байх.

Цант-Орхон ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч Г.Батцэцэгт:

1. Санхүүгийн тайлан гаргах болон бусад шаардлагатай үед өр, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.
2. Бэлэн мөнгөөр хийгдэж байгаа дараа тайлангийн тооцоог холбогдох заавар, маягтын дагуу гаргаж, шаардлагатай анхан шатны баримтыг бүрдүүлж байх.
3. Санхүүгийн програмыг иж бүрэн ашиглаж, борлуулалтын, өглөг, авлагын, үндсэн хөрөнгийн журналуудыг бодитой хөтөлж санхүүгийн тайланг гаргаж байх.
4. Шатахууны бүртгэл, хөдөлгөөнийг бодитой хөтөлж, үлдэгдлийг бодитой илэрхийлж байх.

Холбогдох байгууллагын санал

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны 10 дугаар сарын 2 өдрийн 176 дугаар албан бичгээр тус аудитын тайлангийн төслийг хүргүүлсэн бөгөөд Цант-Орхон ХХК-ийн 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 88 дугаар албан бичгээр илэрсэн зөрчлийг арилгаж, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар хариуг ирүүллээ.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Б.ЭРДЭНЭЗУЛ